

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/01/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойр хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543156
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Утас: 70543179
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Аудитор: Б.Анхтуяа
Утас: 70543179
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага	13
3.5.3 Урьдчилгаа	14
3.5.4 Бараа материал	14
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	15
3.5.6 Өр төлбөр.....	16
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	16
3.5.8 Орлогын данс.....	17
3.5.9 Зардлын данс.....	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
3.6.1 Төсвийн төлөвлөлт	18
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	18
3.6.3 Нэмэлт төсөв.....	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	20
3.8 Аудитын гол асуудал	20
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	20
3.9.1 Шилэн дансны мэдээлэл.....	20
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	21
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.11 Дараагийн аудитаар анхаарал асуудал.....	21
4. Аудитын илрүүлэлт	21
4.1 Харьяа байгууллагууд	22
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч	22
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга.....	22
4.2.2 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага	23
4.2.3 Зөвлөмж	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУБ	Олон улсын байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

1. Аудитын гэрчилгээ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		3,560,717.8	3,758,663.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	682,182.7	1,004,465.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	997,642.6	815,263.3
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	90,500.0	500.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,757,235.9	1,894,359.5
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	33,156.5	44,075.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		9,739,178.9	9,490,793.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	9,739,178.9	9,490,793.7
39200	Биет хөрөнгө		8,487,320.5	8,242,233.1
39300	Биет бус хөрөнгө	13	1,251,858.4	1,248,560.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		13,299,896.7	13,249,457.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		139,887.9	44,602.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	139,887.9	44,602.0
41300	Өглөг	17а, 17б	139,887.9	44,602.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		13,160,008.8	13,204,855.7
51	Засгийн газрын хувь оролцоо		13,160,008.8	13,204,855.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		5,040,227.7	5,040,227.7
51200	Хуримтлагдсан үр дүн		5,020,117.9	5,095,638.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		3,099,663.3	3,068,989.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		13,299,896.7	13,249,457.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		11,216,813.8	10,009,045.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		792,362.0	993,579.3
110	Орлогын албан татвар		577,073.9	668,547.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		577,073.9	668,547.6
113	Хөрөнгийн албан татвар		3,607.0	60,567.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж		211,681.0	264,464.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,492,977.6	1,529,633.4
120	Нийтлэг татварын бус орлого		1,492,977.6	1,529,633.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		8,931,474.2	7,485,832.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	10,581,449.9	9,774,276.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		10,581,449.9	9,688,063.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,186,468.2	9,412,081.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,824,709.2	5,142,217.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		586,426.3	714,101.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		538,224.8	566,255.6
2104	Хангамж, бараа материалын зардал		642,037.7	515,281.2
2105	Нормативт зардал		231,485.0	832,345.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		31,321.8	39,075.9
2107	Томилолт, зочны зардал		12,847.4	8,155.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		441,022.0	450,500.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		878,394.0	1,144,149.5
212	ТАТААС		127,841.8	127,708.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,267,139.9	148,273.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	86,213.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		635,363.9	234,769.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	2,503.0

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,306.8	1,869.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		632,057.1	235,403.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		10,182,303.1	9,088,676.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		792,362.0	993,579.3
110	Орлогын албан татвар		577,073.9	668,547.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		577,073.9	668,547.6
113	Хөрөнгийн албан татвар		3,607.0	60,567.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж		211,681.0	264,464.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		133,377.7	169,605.2
1181	Газрын төлбөр		59,795.4	89,581.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		18,507.9	5,277.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		448,317.0	715,318.4
120	Нийтлэг татварын бус орлого		448,317.0	715,318.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		8,941,624.2	7,379,778.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,662,670.9	8,129,939.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,662,670.9	8,129,939.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,177,785.6	7,819,016.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,560,268.1	5,178,725.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		581,224.1	675,119.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		532,782.3	568,076.6
2104	Хангамж, бараа материалын зардал		153,661.0	91,913.7
2105	Нормативт зардал		131,649.0	206,272.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		48,455.6	67,524.7
2107	Томилолт, зочны зардал		12,541.4	8,155.4

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		450,611.2	454,215.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		706,592.9	569,013.4
212	ТАТААС		127,841.8	127,708.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,357,043.5	183,214.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		519,632.3	958,736.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		354,808.6	635,853.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		354,808.6	635,853.7
2200	Дотоод эх үүсвэрээр		354,808.6	635,853.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-354,808.6	-635,853.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		0.0	-600.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		0.0	600.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		164,823.7	322,282.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		517,359.0	682,182.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		682,182.7	1,004,465.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,343,377.7	0.0	12,343,377.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-864.0	0.0	-864.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,342,513.6	0.0	12,342,513.6

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	163,514.1	0.0	163,514.1
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	21,924.0	0.0	21,924.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	632,057.1	0.0	632,057.1
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,160,008.8	0.0	13,160,008.8
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,160,008.8	0.0	13,160,008.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-159,882.4	0.0	-159,882.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,000,126.4	0.0	13,000,126.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-30,673.7	0.0	-30,673.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	235,403.0	0.0	235,403.0
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	13,204,855.7	0.0	13,204,855.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,385,812.2	8,007,512.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,622,611.5	7,580,712.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,351,847.1	7,310,650.2

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,871,035.3	4,858,624.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	641,196.2	637,586.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	581,341.3	566,888.0
2104	Хангамж, бараа материалын зардал	51,192.8	50,991.4
2105	Нормативт зардал	110,569.6	107,580.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	139,143.6	139,074.1
2107	Томилолт, зочны зардал	9,441.5	6,797.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	448,803.1	448,590.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	499,123.7	494,518.2
212	ТАТААС	127,708.6	127,708.6
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	127,708.6	127,708.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,055.8	142,353.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,500.0	15,499.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	127,555.8	126,854.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	561,462.7	426,200.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	201,738.0	600.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,385,812.2	8,273,933.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,092,553.3	6,082,892.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,951,520.9	1,923,806.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	341,738.0	267,234.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	238,965.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	505,386.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	4,483.0	4,843.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	18.00	18.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	335.00	346.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	3,795.00	4,133.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	2,632.00	2,869.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1,163.00	1,264.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	335.00	346.00

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	219,283.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	113,410.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	107,718.09
2104	Хангамж, бараа материалын зардал	48,683.50
2105	Нормативт зардал	1,031.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,674.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,529.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,692.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	450.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,242.75
22	Хөрөнгийн зардал	105,873.10
2200	Дотоод эх үүсвэрээр	105,873.10
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	219,283.94
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	219,283.94

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу “Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд аудитын дүнг үндэслэн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэх, сумын төсвийг батлахдаа ОНХС-гийн хэмнэлтийг үнэн зөв тооцож батлуулах талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-наас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн аудитор Б.Анхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/119 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Нутгийнхаа өвөрмөц онцлог, экологийн тэнцвэрийг хадгалан, үр ашигтай шударга бизнес, тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэн, хуулиа дээдлэн хүний хөгжлийг хангасан, Боржигин түмний уламжлалт ёс заншлыг өвлөн дээдэлсэн, орон нутгийн нөөц, дэд бүтцийн давуу хөгжилд түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээ, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй бүхий эдийн засгийн чадавхтай сум болох, иргэн бүр нутаг орондоо ая тухтай амьдрах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэн, төрийн бүх үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэж, ардчилсан шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг ханган ажиллана” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах чиг үүргүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 онд харьяа газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 8,411.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 84.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 58.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50.4 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 682.2 сая, эцсийн үлдэгдэл 1,004.5 сая төгрөг болж, 322.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	682.2	1,004.5	322.3	100
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-

Дүн	682.2	1,004.5	322.3	100
------------	--------------	----------------	--------------	------------

Эх сурвалж: “Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 874.2 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 67.7 сая төгрөг арилжааны банкны дансанд, 15.8 сая төгрөг ахмадын сангийн дансанд, 41.6 сая төгрөг барьцаа дансанд, 5.2 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Хадгаламж дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 997.6 сая, эцсийн үлдэгдэл 815.3 сая төгрөг болж, 182.3 сая төгрөгөөр буурсан байна. Авлага дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.4	1.6	-0.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	48.6	148.6	100.0
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	35.0	25.0	-10.0
Бусад авлага	911.6	640.1	-271.5
Зээлийн авлага	-	-	-
Дүн	997.6	815.3	-182.3

Эх сурвалж: “Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангийн үндсэн болон зээлийн хүүгийн авлага 675.5 сая, ажиллагчидтай холбогдсон авлага 1.6 сая, өрхийн эмнэлгийн ковидын санхүүжилтийн авлага 137.2 сая, бусад авлага 1.0 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 689.7 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сүмбэр сумын Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 69 зээлдэгчийн 648.0 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс 5 зээлдэгчийн 44.8 сая төгрөгийн авлага хэвийн, 12 зээлдэгчийн 58.2 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, 12 зээлдэгчийн 125.0 сая төгрөгийн авлага шүүхэд шилжүүлэх, 10 зээлдэгчийн 146.9 сая төгрөгийн авлага ШШГГ-т шилжүүлэх, 8 зээлдэгчийн 19.2 сая төгрөгийн авлага мэдэгдэл хүргүүлсэн, 4 зээлдэгчийн 14.6 сая төгрөгийн авлага шүүхэд шилжүүлсэн, 10 зээлдэгчийн 115.4 сая төгрөгийн авлага ШШГГ-т шилжсэн, 8 зээлдэгчийн 123.9 сая төгрөгийн авлага найдваргүй болсон байна.

Эдгээр нь Сум хөгжүүлэх сангийн эргэлтийн хөрөнгө бүрдэхгүй байх, зардлын үр ашиг буурах үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх болон тайлант онд үүссэн 1.7 сая төгрөгийн авлага барагдуулаагүй /Сүмбэр сумын 5-р сургууль 1.5 сая, Сүмбэр сумын 2-р цэцэрлэг 0.2 сая /

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 90.5 сая, эцсийн үлдэгдэл 0.5 сая төгрөг болж, 90.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	90.0	0.0	-90.0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	-	-
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	-	-
Цалингийн урьдчилгаа	0.5	0.5	-
Томилолтын урьдчилгаа	-	-	-
Дүн	90.5	0.5	90.0

Эх сурвалж: “Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд өмнөх онд үүссэн 0.5 сая төгрөгийн төсөвт байгууллагын цалингийн урьдчилгааг хаагаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Он дамжсан 0.5 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг барагдуулаагүй /Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэг /

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1,790.4 сая, эцсийн үлдэгдэл 1,938.4 сая төгрөг болж, 148.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	25.2	48.5	23.3
Эм боох материал	33.8	69.4	35.6
Бичиг хэргийн материал	9.1	8.4	-0.7
Аж ахуйн материал	452.4	457.2	4.8
Сэлбэг хэрэгсэл	0.0	0.0	0.0
Түлш, шатах тослох материал	3.2	2.3	-0.9
Барилгын засварын материал	2.7	7.3	4.6
Хүнсний материал	6.1	22.4	16.3
Бусад хангамжийн материал	1,166.5	1,220.6	54.1
Мал амьтад	58.2	58.2	-
Нөөцийн бараа	33.2	44.1	10.9
Дүн	1,790.4	1,938.4	148.0

Эх сурвалж: “Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд нөөцөлсөн болон ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

Бараа материалын данс нь худалдан авсан 497.4 сая, ОУБ, иргэд болон ААНБ-ын хандиваар 38.3 сая, шилжүүлэн авсан 43.7 сая, улсын болон орон нутгийн төсөв, харьяа яам, аймаг сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 756.4 сая, нийт 1,335.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,066.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, шилжүүлсэн 23.2 сая, байгууллагын даргын тушаалаар акталж данснаас хассан 98.5 сая, нийт 1,187.8 сая төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- *Бараа материалын тайланг данс тус бүрээр бэлтгээгүй, тодруулга тайланд ангилал зөрүүтэй бүртгэсэн байсныг тус тус залруулсан / Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 7.3 сая, Сүмбэр сумын 2 дугаар сургууль 11.0 сая, Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг 1.7 сая, Сүмбэр сумын 5 дугаар сургууль 17.8 сая, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 15.9 сая, Өрхийн эрүүл мэндийн төв 8.4 сая /*

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 11,737.9 сая, эцсийн үлдэгдэл 11,630.7 сая төгрөг болж, 107.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	8,062.5	7,774.8	-287.7
Тээврийн хэрэгсэл	132.6	80.7	-51.9
Машин тоног төхөөрөмж	870.1	1,046.1	176.0
Тавилга эд хогшил	670.4	728.5	58.1
Номын фонд	2.5	2.5	-
Бусад үндсэн хөрөнгө	739.6	738.5	-1.1
Программ хангамж	36.3	35.7	-0.6
Бусад биет бус хөрөнгө	1,223.9	1,223.9	-
Дүн	11,737.9	11,630.7	107.2

Эх сурвалж: “Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 123.4 сая, балансас балансад шилжүүлэн авсан 47.7 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 125.2 сая, улсын болон орон нутгийн төсөв, харьяа яам, аймаг сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 569.0 сая, дахин үнэлгээ 472.1 сая, нийт 1,337.5 сая төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 235.8 сая, бусад 672.6 сая, дахин үнэлгээгээр хасагдсан 536.4 сая, нийт 1,444.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- *Барилга байгууламж дансанд дахин үнэлгээ хийгээгүй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа дахин үнэлгээний хорогдол дансанд бүртгэсэн байсныг тус тус залруулсан / Сүмбэр сумын ЗДТГ 110.8 сая, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 472.1 сая /*
- *Үндсэн хөрөнгийн дансанд ангилал зөрүүтэй бүртгэсэн / Сүмбэр сумын 5 дугаар сургууль 140.4 сая /*

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 139.9 сая, эцсийн үлдэгдэл 44.6 сая төгрөг болж, 95.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	139.9	44.6	-95.3	100.0
Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.2	1.8	1.6	4.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	0.0	-	-
Бусад өглөг	139.6	42.8	-96.8	96.0
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	-	-	-	-
Нийт дүн	139.9	44.6	95.3	100.0

Эх сурвалж: “Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 41.6 сая төгрөгийн барьцаа, ажиллагчидтай холбогдсон өглөг 1.8 сая, бусад өглөг 1.2 сая, нийт 44.6 сая төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөр тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Завсрын аудитаар 4.3 сая төгрөгийн НДШ-ийн зардалд өр төлбөртэй байсныг залруулсан / Сүмбэр сумын ЗДТГ 4.3 сая /
- Тайлант онд өр төлбөртэй тайлагнасан / Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 0.8 сая, Сүмбэр сумын 5 дугаар сургууль 2.4 сая /

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 13,160.0 сая, эцсийн үлдэгдэл 13,204.8 сая төгрөг болж, 44.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,040.2	5,040.2	-	38.2
Өмч /төрийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	5,019.2	4,935.8	-83.4	37.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,099.7	3,068.9	-30.8	23.2
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.9	159.9	159.0	1.2
Дүн	13,160.0	13,204.8	44.8	100

Эх сурвалж: “Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 13,204.8 сая төгрөг болж 44.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн, дахин үнэлгээний өсөлт бууралт, бодлогын өөрчлөлт алдааны залруулгаас шалтгаалжээ. Үүнд:

- Төрийн өмчийн дансанд эхний эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.
- Хувийн өмчийн дансанд эхний эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.
- Хувьцааны дансанд эхний эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.
- Халаасны хувьцааны дансанд эхний эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.
- Нэмж төлөгдсөн капитал дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 30.8 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийг дахин үнэлснээс шалтгаалжээ.

Эздийн өмчийн бусад хэсэг дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Хуримтлагдсан үр дүн 5,095.6 сая төгрөг болж 76.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн, бодлогын өөрчлөлт алдааны залруулга данснаас шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд нягтлан бодох бүртгэлийн бичилтийн алдааны залруулга хийгдсэнээс шалтгаалж бүртгэгдсэн 159.9 сая төгрөгийн алдааны залруулга байна.

Аудитын илрүүлэлт:

Засгийн газрын хувь оролцооны данстай холбоотой зөрчил илрээгүй байна.

3.5.8 Орлогын данс

Нэгтгэсэн орлого үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогод Өрхийн эрүүл мэндийн төвийн орлого 358.0 сая, Сум хөгжүүлэх сангийн орлого 19.3 сая, нийт 377.3 сая, туслах үйл ажиллагааны орлогод Өрхийн эрүүл мэндийн төвийн орлого 71.6 сая, ахмадын сангийн орлого 14.0 сая, нийт 85.6 сая төгрөгийг тайлагнасан байна.

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогод Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого 267.2 сая, Өрхийн эрүүл мэндийн төвийн орлого 358.0 сая, нийт 625.2 сая, туслах үйл ажиллагааны орлогод Өрхийн эрүүл мэндийн төвийн орлого 71.6 сая, ахмадын сангийн орлого 14.0 сая, нийт 85.6 сая төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Орлого, үр дүнгийн тайланд хөрөнгийг дахин үнэлж орлогод авахдаа дахин үнэлгээний нэмэгдэл дансанд орлого бүртгэсэн /Сүмбэр сумын ЗДТГ 39.4 сая /

3.5.9 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 364.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- *Цалин, ээлжийн амралтыг давхардуулан олгосон, улирлын үр дүнгийн урамшууллыг хэтрүүлэн олгосон, тэтгэмж, тусламж олгохдоо ХХОАТ суутгаагүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, хуурамч баримт бүрдүүлэн худалдан авалт хийж орлого зарлагаар бүртгэсэн нийт 21.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон / Сүмбэр сумын ИТХ 0.3 сая, Сүмбэр сумын ЗДТГ 0.7 сая, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 20.3 сая /*

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж, албан конторын тавилгын худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн /Сүмбэр сумын ЗДТГ 24.9 сая /*
- *Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтын дүнг тулган баталгаажуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй нийт 131.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн, 50.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 81.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж / Сүмбэр сумын ОНХС 31.2 сая, Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 9.0 сая, Сүмбэр сумын 2 дугаар сургууль 2.7 сая, Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг 37.9 сая, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг 1.6 сая, Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэг 13.6 сая, Өрхийн эрүүл мэндийн төв 35.0 сая /*

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийг аймгийн ТЕЗ-аас батлан ирүүлсэн төсвийн хүрээнд сумын ИТХ-аар хэлэлцүүлж сумын төсвийн татварын орлого, тусламжийн орлого, зарлагын хэмжээ, хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг баталдаг байна.

Сүмбэр сумын ИТХ-ын 2020 оны 07, 2021 оны 03 дугаар тогтоолоор сумын татварын орлого 670.5 сая, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 1,006.0 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих 244.8 сая, тэнцлийн ашгаас 275.0 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 5,847.7 сая, сум хөгжүүлэх сангийн орлого 201.7 сая, ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих 140.0 сая, нийт 8,385.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 8,385.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 7,580.7 сая төгрөгийг урсгал зардалд, 426.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 0.6 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 5,847.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 244.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,951.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 105.6 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 236.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 5,847.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 244.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,951.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 236.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс нийт 8,385.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 267.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 65.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,007.5 сая төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь зардал хэмнэгдэж зарцуулагдсантай холбоотой байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 12.4 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 3.6 сая, тогтмол зардлыг 14.5 сая, хангамж, бараа материалын зардлыг 0.2 сая, нормативд зардлыг 3.0 сая, эд хогшил, урсгал засвар зардлыг 0.07 сая, томилолт зочны зардлыг 2.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр зардлыг 0.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 4.6 сая, урсгал шилжүүлэг зардлыг 0.7 сая, хөрөнгийн зардлыг 135.3 сая, эргэж төлөгдөх зээл зардлыг 201.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 37.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 23 төсөл, арга хэмжээнд 659.8 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 511.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, 4.5 сая төгрөгийг барьцаа дансанд, 3.7 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Сүмбэр сумын ИТХ-ын сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай 03 дугаар тогтоолоор Сүмбэр сумын Засаг дарга тайлант онд 670.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 993.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 48.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	32.5	153.1	120.6	100
Хөрөнгийн орлого	176.0	247.4	71.4	41
Хөрөнгө борлуулсны орлого	45.5	191.2	145.7	100
Шууд бус орлого	150.0	61.0	-89.0	-59.3
Бууны албан татвар	3.1	3.8	0.7	22.5
Улсын тэмдэгтийн хураамж	35.0	23.4	11.6	-33.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	15.0	25.9	10.9	72.6
Агнуурын нөөцийн төлбөр	0.0	5.3	5.3	100
Газрын төлбөр	111.4	89.6	21.8	-19.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	87.0	120.3	33.3	38.2
Малд ногдуулах албан татвар	0.0	56.8	56.8	100
Бичил үйл ажиллагааны орлогын албан татвар	15.0	15.7	0.7	4.7
Нийт дүн	670.5	993.6	323.1	48.2

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 323.1 сая төгрөгөөр давж биелсэн боловч 3 нэр, төрлийн татварын орлогын төлөвлөгөө биелээгүй байна. Тухайлбал,

Шууд бус орлого 89.0 сая буюу 59.3%, улсын тэмдэгтийн хураамж 11.6 сая буюу 33.1%, газрын төлбөр 21.8 сая буюу 19.6%-иар тус тус тасарсан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар өвсний орлого 21.5 сая, орцны хаалганы орлого 18.0 сая, БСШУЯ-наас 48.9 сая, ХХҮГ-аас 15.0 сая, засаг даргын нөөц хөрөнгөөс 3.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 1.6 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 17.1 мянга, ГБХЗХГ болон БСУГ-аас 3.0 сая, өмнөх оны үлдэгдэл санхүүжилт 90.0 сая, бусад 1.0 сая, нийт 219.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 48.7 сая, нормативт зардалд 1.0 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 4.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардалд 2.7 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 50.5 сая, бусад урсгал шилжүүлэг зардалд 0.5 сая, хөрөнгийн зардалд 105.9 сая, нийт 214.1 сая төгрөгийг зарцуулж, 5.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан ИТХ-ын үйл ажиллагаа, Засаг даргын ажлын алба, Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, Ерөнхий боловсролын үйлчилгээ, Эрүүл мэндийн удирдлага хөтөлбөрийн хүрээнд нийт 5 үзүүлэлтийн зорилтот түвшинд 8,219.2 мянган төгрөг баталснаас гүйцэтгэлээр 98.4 хувийн биелэлттэй байна.

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан зорилтот түвшиндээ хүрсэн байна.

Шалгагдагч байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилт 98.4 хувь, батлагдсан төсвийн гүйцэтгэл 95.5 хувьтай байна.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 1793 мэдээлэл байршуулахаас 1693 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийн хугацаа болоогүй, 76 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 425.7 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 425.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага 4 байгууллагад хүргүүлж, 5 байгууллагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг өгсөн байна.

3.10 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 377.8 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрсэн ба 320.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 57.2 сая төгрөгийн 7 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 11 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	7	57.2	7	57.2	-	-	-
Нийт дүн	7	57.2	7	57.2	-	-	-

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАЛ АСУУДАЛ

ТТЗ-аас боловсролын салбарын удирдлагуудын ур чадвар, үр дүнг үнэлэхдээ холбогдох журмыг мөрдөөгүй, хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэр гаргаж байгаа нь алдаа зөрчил гаргах эрсдэлийг нэмэгдүүлж байгаа тул дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц асуудал байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,025.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 974.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 21.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 219.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 510.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчлийн 385.1 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас давсан боловч шинж чанарын хувьд материаллаг бус тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 10 төсвийн байгууллага 2 тусгайн сангийн, нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 7 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,782.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 856.1 сая төгрөгийн 24 алдааг аудитын явцад залруулж, 21.2 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 219.4 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 385.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 23 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн аудитаар 383.2 сая төгрөгийн 4 албан шаардлага, 42.6 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 33.9% буюу 452.0 сая, төлбөрийн акт 41.3% буюу 6.2 сая, албан шаардлага 5 дахин буюу 493.7 сая, зөвлөмж 284.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын 63.6% буюу 383.2 сая, зөвлөмжийн 14.1% буюу 42.6 сая төгрөг нь Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил байна. /Хавсралт 2-оос үзнэ үү/

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нийт 243.2 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлснээс 118.0 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 125.2 сая төгрөгийн 2 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 125.2 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайланд яам, бусад хөрөнгө оруулалт, хандиваар хүлээн авсан 91.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авснаар нэгтгэсэн, бараа материалын тодруулга тайланд БСУГ болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 2.6 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар нэгтгэсэн
- Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 23.8 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор нэгтгэсэн

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд тус тус залруулга хийгдээгүй байна.
- Нэгтгэгдсэн байгууллага хооронд болон төсвийн төвлөрүүлэн захирагч хооронд залруулга хийгдээгүй байна.

4.2.2 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлээгүй байна.

4.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.1 Орлогын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч 3 нэр төрлийн татварын орлого 122.3 сая төгрөгөөр тасарсан, хуулиар тогтоосон татварын орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.2, 23.8.8, 23.8.14, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.9 дэх заалтуудыг зөрчсөн, Эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Сумын татварын орлогын төлөвлөгөөг нэр, төрлөөр нь бүрэн биелүүлж ажиллах

4.2 Зардлын данстай холбоотой асуудал

1.2. Илрүүлэлт:

Сумын төсөвт 2020 оны ОНХС-ийн хэмнэлтийг 2.8 сая төгрөгөөр дутуу батлуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтуудыг зөрчсөн, Эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.3. Өгсөн зөвлөмж:

Өмнөх оны ОНХС-гийн хэмнэлтийг сумын төсөвт бүрэн батлуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган
төгрөгөөр/

д/ д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
1	Сүмбэр сумын Засаг дарга	ГСА-2022/01/СТА-ТТЗ		1					5	243,227.4	3	118,034.2							2	125,193.2
ДҮН				1					5	243,227.4	3	118,034.2							2	125,193.2

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
1	Сүмбэр сумын Засаг дарга	ГСА-2022/01/СТ А-ТТ3	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

**Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэл / тайлант он, өмнөх онтой
харьцуулсан харьцуулалт /**

№	Огноо	Зөрчлийн дүн	Шийдвэрлэсэн байдал /Сая төгрөгөөр/						
			Залруулсан	Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант он	1,782.3	856.1	4	21.2	13	602.6	26	302.4
2	Өмнөх он	1,330.3	1,188.5	21	15.0	14	108.9	15	17.9
Зөрүү		-452.0	332.4	17	-6.2	1	-493.7	-11	-284.5